



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 122,916,647.46 (нэг зуун хорин хоёр сая есөн зуун арван зургаан мянга зургаан зуун дөчин долоон төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 108,978,454.72 (нэг зуун найман сая есөн зуун далан найман мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ландкруйзер-200 маркийн 2 ширхэг автомашиныг хавсралтад заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа Говь Алтай аймгийн Автотээврийн төвд, Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний газарт тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсөронзон, Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний газрын дарга М.Мянганбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т уүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001260

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05-ны 9. Одугаар тогтоолын хавсралт

**“МЭДЭЭЛЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Автомашины Марк услсын дугаар	Ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хурумтлагдсан эпэгдэл	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
				Балансын нийт үнэ	Хурумтлагдсан эпэгдэл	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Ландкруйзер-200 44- 89 УБҮ	2012.01.24	JTMDU09J7B40 41836	17,217,767.46	3,279,574.72	13,938,192.74	“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчийт үйлдвэрийн газар
2	Ландкруйзер-200 43- 57 УНГ	2010.05.06	JTMHU09J7040 17079	105,698,880.00	105,698,880.00	-	Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
				122,916,647.46	108,978,454.72	13,938,192.74	
				/Нэг зуун хорин хойр сая есөн зүүн арван зургаан мянга зургаан зуун дөчин долоон төгрөг дөчин зургаан мөнгө/ НИЙТ ДҮН	/Нэг зуун найман сая есөн зуун далан найман мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг далан хоёр мөнгө/	/арван гурван сая есөн зуун гучин найман мянга нэг зуун ерэн хоёр төгрөг далан дөрвөн мөнгө/	